



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61000 Эрдэнэт хот, Амарын талбай,
УБД 2070001050, Нутгийн удирдлагын ордон
Утас/Факс: 70359826
E-mail: orkhon@audit.gov.mn

2017.10.26 № 194
танай _____-ны № _____-т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар хийгдсэн "Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүн" гүйцэтгэлийн аудитын тайланг хүргүүлж байна.

Хавсралт 2. хуудастай.


ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



НАРМАНДАХ

07 03 15

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторов 2017 оны 10 дугаар сарын 25 өдрийн 19 тоот тушаалын хавсралт



Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт

Д/Д	Зөрчлийн товч утга	Зөрчил хариуцагч байгууллага	хариуцагч		Зөрчил	Алдаа
			Албан тушаал	Нэр		
1	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хөрөнгөнөөс задлан шинжилгээнд оролцсон ажилчдын урамшууллыг олгоход зарцуулсан.	Аймгийн Прокурорын газар	Ерөнхий прокурор, хууль цаазын итгэмжит зөвлөх	Г.Эрдэнэбаатар		850.0
Нийт дүн						850.0



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2017 оны 10 сарын 25 өдөр

Дугаар 19

Эрдэнэт хот

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалт, 19-р зүйлийн 19.3.3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2017 оны А/188 дугаар тушаал, "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.40 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүн" гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Тус аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалтыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Үндэсний аудитын газар болон аймгийн ГХУСАЗЗ, Цагдаагийн газар, Прокурорын газарт тус тус хүргүүлсүгэй.
4. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Б.Эрдэнэ/, аудитор /О.Дашжамц/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.НАРМАНДАХ

07 003 91

**“ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГУУДЫН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”
ОРА-2017/03-ГА**



Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж байгаа боловч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсвийг хуульд зааснаас доогуур төлөвлөн зарцуулжээ.

**Орхон аймаг
2017 он**

Аудитыг гүйцэтгэсэн:

Орхон аймаг дахь
Төрийн аудитын
газрын дарга,
тэргүүлэх аудитор:
Ц.Нармандах

Аудитын менежер:
Б.Эрдэнэ

Аудитор:
О.Дашжамц

2017 оны 10 дугаар сар

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж
лавлах зүйл байвал
70357955, 70350757
дугаарын утас,
70359826 дугаарын
факсаар харилцана уу.

Уг тайланг УАГ-ын веб
сайтаас үзнэ үү.

www.audit.mn

Хаяг: Орхон аймаг
дахь төрийн аудитын
газар

Баян-Өндөр сум,
Хүрэнбулаг баг,
Нутгийн удирдлагын
ордон

Агуулга

Товчилсон үгсийн жагсаалт	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	3

Бүлэг 1. Гэмт хэргийн гарч байгаа шалтгаан, нөхцлийг тогтоох чиг үүргийг хэрэгжүүлснээр хулгайн гэмт хэрэг 15.2 хувь, бусдын бие махбодод гэмтэл учруулах гэмт хэрэг 5.2 хувь, хүн амины хэрэг 30.0 хувь, бусдыг амиа хорлоход хүргэх 50.0 хувь, булаах гэмт хэрэг 50.0 хувь, дээрэм 36.8 хувь, залилан 51.8 хувь, завшиж үрэгдүүлэх 62.9 хувь, танхайрах гэмт хэрэг 7.7 хувь, бусад гэмт хэргүүд 7.3 хувиар тус тус буурч, гэмт хэргийн илрүүлэлт 1.4 пунктээр өссөн байна.

- Гэмт хэргийн гарч байгаа шалтгаан, нөхцлийг тогтоох чиг үүргийн хэрэгжилтийг 2015-2016 онтой харьцуулахад хулгайн гэмт хэрэг 15.2 хувь, бусдын бие махбодод гэмтэл учруулах гэмт хэрэг 5.2 хувь, хүн амины хэрэг 30.0 хувь, бусдыг амиа хорлоход хүргэх 50.0 хувь, булаах гэмт хэрэг 50.0 хувь, дээрэм 36.8 хувь, залилан 48.1 хувь, завшиж үрэгдүүлэх 62.9 хувь, танхайрах гэмт хэрэг 7.7 хувь, бусад гэмт хэргүүд 7.3 хувиар тус тус буурчээ..... 5
- Гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг арилгах нийгэм, эдийн засаг, эрх зүйн арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлж ажилласан байна..... 6
- Давтан гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх зорилгоор хорих ял эдлээд суллагдсан хүнд хуульд заасан журмын дагуу захиргааны хяналтыг тогтоон ажиллаж байна..... 8
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэн болон аж ахуйн нэгжийг татан оролцуулсан байна..... 9
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг иргэдэд мэдээлэх, сурталчлах, сургалт олон удаа зохион байгуулагдаж байгаа ч сургалтын үр дүнг тооцоогүй байна..... 10

Бүлэг 2. Бүх төрлийн гэмт хэргийн тоон үзүүлэлт буурч байгаагаас харахад жил бүрийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд үр дүнтэй хэрэгжсэн байна.

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр өнөөгийн хэрэгцээ шаардлагатай нийцсэн байна..... 12
- ГХУСАЗЗ болон Цагдаа, Прокурорийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлууд давхардаж байна..... 14
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлүүдийн үйл ажиллагаа үр дүнтэй байна..... 14

Бүлэг 3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсөв хуульд зааснаас доогуур төлөвлөгдөн батлагдаж байгаа боловч батлагдсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсвийг хуульд зааснаас 2015 онд 79.7 сая, 2016 онд 136.7 сая, 2017 онд 63.1 сая төгрөгөөр тус тус дутуу төлөвлөсөн байна..... 16
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төсвийн хөрөнгийг ГХУС тухай хуулийн 19 дүгээр зүйлийн дагуу зарцуулж ирсэн байна..... 17
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулагдсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна..... 17
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зориулагдсан зардлаас хуульд зааснаас өөр зориулалтаар хөрөнгө зарцуулсан байна 19

Дүгнэлт 20

Зөвлөмж 20

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний Аудитын газар
ОА	Орхон аймаг
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид
ГХУС	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
ГХУСАЗЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл
ГХУСАЗСЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
БСУГ	Боловсрол соёл, урлагын газар
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ОНХ	Олон нийттэй харилцах
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ААН	Аж ахуйн нэгж
ТББ	Төрийн бус байгууллага
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ГА	Гүйцэтгэлийн аудит

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, аудит хийх үндэслэл:

Аудит хийх үндэслэл: Аудитыг Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудитор ТҮАГ-аас 2017 онд нийлүүлэх аудитын болон ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ТҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт: Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ, уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийнэ. Үүнд:

- Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэлийг үр дүнтэй хэрэгжүүлж байгаа эсэх.
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр үр дүнтэй эсэх.
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төсвийн хөрөнгө үр ашигтай зарцуулагдаж буй эсэх.

Аудитын хамрах хүрээ: Аудитад аймгийн ИТХ-ын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл /ГХУСАЗЗ/, Прокурорын газар, Шүүхийн тамгын газар, ОБГ, Цагдаагийн газар, Баян-Өндөр, Жаргалант сумдын ИТХ, ЗДТГ-уудын 2015-2017 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн, хэрэгжүүлсэн арга хэмжээ, хамтын ажиллагаа, шийдвэр гаргалт, тэдгээрийн үр нөлөө, хэрэгжилтийн талаарх тайлан, мэдээ, ажлын баримт материал, үнэлгээ дүгнэлт хамрагдлаа.

Аудитын арга зүй: Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандартыг ашиглахын зэрэгцээ захиалагч байгууллагуудын төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн баримт материалд судалгаа хийх, хариуцсан албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, гүйцэтгэгч байгууллагын тайлан, ажлын гүйцэтгэлийн баримт материалд тулгуурлан баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх, түүвэрчлэн шалгаж үр ашигт байдлыг үнэлэхийн зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу газар дээр нь очиж биет болон баримтат нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт: Дараах хууль эрх зүйн акт, бодлогын бичиг баримтыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглалаа.

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх журам
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөр
- Цагдаагийн албаны тухай хууль
- Прокурорын тухай хууль
- Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль
- Захиргааны хариуцлагын тухай хууль
- Захиргааны ерөнхий хууль
- Замын хөдөлгөөний дүрэм
- Иргэний хууль
- Эрүүгийн хууль
- Прокурорын байгууллагын тухай хууль
- Гэр бүлийн тухай хууль
- Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль
- Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль
- Орхон аймгийн Засаг даргын 2012-2016, 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр

Гүйцэтгэсэн хугацаа: Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг 2017 оны 09 сарын 18-аас эхлүүлэн, талбарын ажлыг 10 сарын 02-оос эхлүүлж, аудитын тайланг 10 дугаар сарын 15-аас эхэлж, тайлангийн төслийг 10 дугаар сарын 23-нд аймгийн аудитын газрын удирдлагад танилцуулан, 10 дугаар сарын 25-нд Үндэсний аудитын газарт баталгаажуулан хүргүүлээ.

Үндсэн мэдээлэл: Орхон аймаг нь 2 сумтай, аж үйлдвэр, үйлчилгээний салбар илүүтэй хөгжсөн Баян-Өндөр сум, хөдөө аж ахуйн салбар хөгжсөн Жаргалант сумаас бүрдсэн 101891 хүн амтай. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 1998 оны 2 дугаар сарын 24-ны өдрийн 08 дугаар тогтоолоор Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах аймгийн зөвлөлийн ажиллах журмыг баталсан. Уг журмыг 2016 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн 143 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь хууль сахиулах, төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, иргэд оролцсон өргөн цар хүрээтэй ажил байхаар хуульчлагдсан бөгөөд аймгийн ГХУСА33-ийн хурлаар жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баталжээ.

Орхон аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг хангах болон бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр 10 зорилт дэвшүүлсэн байна.

Орхон аймагт 2017 оны эхний хагас жилийн байдлаар хөнгөн ангиллын гэмт хэрэг 2016 онд 146 байсан бол 166 болж өссөн, Хүндэвтэр ангиллын гэмт хэрэг 177 байсан бол 168 болж буурсан, Онц хүнд ангиллын гэмт хэрэг 5 байсан бол 4 болж буурсан, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг 3 байсан бол 4 болж өссөн, танхайрах гэмт хэрэг 5 байсан бол 7 болж өссөн, хүчиндэх гэмт хэрэг 5 байсан бол 10 болж хоёр дахин өссөн, хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 123 байсан бол 162 болж өссөн, хүний амь нас хөнөөсөн гэмт хэрэг 2 байсан бол 1 болж буурсан, бусдын эд хөрөнгийг булаах гэмт хэрэг 3 байсан бол 1 болж буурсан, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэрэг 18 байсан бол 17 болж буурсан, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 31 байсан бол 15 болж буурсан, бусад төрлийн гэмт хэрэг 83 байсан бол 42 болж буурсан үзүүлэлт гарсан байна.

Гэмт хэргийн 15-н ангиллаар өссөн 7, буурсан үзүүлэлт 8 байна. Гэмт хэргийн улмаас 9 хүний амь нас хохирч, 75 хүний биед гэмтэл учирч 351.2 сая төгрөгийн материаллаг хохирол учирсанаас шүүхийн шатанд 71.2 сая төгрөгийг нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэг үйлдсэн нутаг дэвсгэрийн хувьд 42 гэмт хэрэг гудамж талбай, олон нийтийн газар, 114 гэмт хэрэг иргэдийн орон байранд, 32 гэмт хэрэг ажлын байранд тус тус үйлдэгдсэн. Гарсан гэмт хэргийн 40 хувь нь орон сууцны хороололд, 57 хувь нь гэр хороололд, 3 хувь нь Жаргалант сумын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь хууль сахиулах, төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, иргэд оролцсон өргөн цар хүрээтэй ажил байхаар хуульчлагдсан бөгөөд аймгийн хувьд бүх шатны ИТХ, Цагдаагийн газар, Прокурорын газар голлох байр суурьтай оролцсон байна.

Орхон аймаг дахь
Төрийн аудитын
газарХууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
ажлын үндсэн чиглэлийг үр дүнтэй хэрэгжүүлж байна уу.

Бүлэг 1

Гэмт хэргийн гарч байгаа шалтгаан, нөхцлийг тогтоох чиг үүргийг хэрэгжүүлснээр хулгайн гэмт хэрэг 15.2 хувь, бусдын бие махбодод гэмтэл учруулах гэмт хэрэг 5.2 хувь, хүн амины хэрэг 30.0 хувь, бусдыг амиа хорлоход хүргэх 50.0 хувь, булаах гэмт хэрэг 50.0 хувь, дээрэм 36.8 хувь, залилан 51.8 хувь, завшиж үрэгдүүлэх 62.9 хувь, танхайрах гэмт хэрэг 7.7 хувь, бусад гэмт хэргүүд 7.3 хувиар тус тус буурч, гэмт хэргийн илрүүлэлт 1.4 пунктээр өссөн байна.

1.1 Гэмт хэргийн гарч байгаа шалтгаан, нөхцлийг тогтоох чиг үүргийн хэрэгжилтийг 2015-2016 онтой харьцуулахад хулгайн гэмт хэрэг 15.2 хувь, бусдын бие махбодод гэмтэл учруулах гэмт хэрэг 5.2 хувь, хүн амины хэрэг 30.0 хувь, бусдыг амиа хорлоход хүргэх 50.0 хувь, булаах гэмт хэрэг 50.0 хувь, дээрэм 36.8 хувь, залилан 48.1 хувь, завшиж үрэгдүүлэх 62.9 хувь, танхайрах гэмт хэрэг 7.7 хувь, бусад гэмт хэргүүд 7.3 хувиар тус тус буурчээ.

Цагдаагийн байгууллагын чиг үүргийн нэг нь Цагдаагийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1-т зааснаар “гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг гарсан шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгуулах” гэж тусгагджээ.

Аймгийн хэмжээнд 2015 онд 566, 2016 онд 528, 2017 оны эхний хагас жилд 353 гэмт хэрэг гарсан байна. Гэмт хэргүүдийг ангилан харуулбал:

Хэргийн төрөл	2015	2016	/тоогоор/ 2017.06.30.
Хулгай	197	167	104
Бусдын бие махбодод гэмтэл учруулсан	230	218	126
Хүний амь насыг санаатай хохироосон	10	7	3
Бусдыг амиа хорлоход хүргэх	6	3	3
Хүчиндэх	14	14	8
Булаалт	4	2	1
Дээрэм	19	12	4
Залилан	27	13	18
Завшиж үрэгдүүлэх	27	17	15
Танхайрах	13	12	11
Бусад	68	63	60
Нийт	566	528	353

2015-2017 онд үйлдэгдсэн нийт гэмт хэргийн 32.2 хувийг хулгайн гэмт хэрэг, 39.6 хувийг бусдын бие махбодод гэмтэл учруулах гэмт хэрэг, 28.2 хувийг бусад гэмт хэргүүд эзэлж байна.

Гэмт хэргийн гаралтаар 2016 оныг 2015 онтой харьцуулан үзэхэд залилан мэхлэх гэмт хэрэг 51.8 хувь, хулгайн гэмт хэрэг 15.2 хувь, бусдын бие махбодод гэмтэл учруулах гэмт хэрэг 5.2 хувь, хүн амины хэрэг 30.0 хувь, бусдыг амиа хорлоход хүргэх 50.0 хувь, булаах гэмт хэрэг 50.0 хувь, дээрэм 36.8 хувь, залилан 48.1 хувь, завшиж үрэгдүүлэх 62.9 хувь, танхайрах гэмт хэрэг 7.7 хувь, бусад гэмт хэргүүд 7.3 хувиар тус тус буурчээ.

Харин 2017 оны эхний хагас жилийн дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулахад бусдын бие махбодод гэмтэл учруулах, хулгай, залилан, завшин үрэгдүүлэх, танхайрах хэргүүд өссөн, хүний амь насыг санаатай хороох, бусдыг амиа хорлоход хүргэх, хүчиндэх гэмт хэргүүд буурсан үзүүлэлттэй бөгөөд нийт гэмт хэргийн тоо 11.4 хувиар өссөн байна.

Цагдаагийн газрын кримнологи судалгааны баг жил бүр үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчилд дүн шинжилгээ хийн, зонхилон үйлдэгдэж байгаа дээрэм, булаалт, хулгай, бусдын

бие махбодид гэмтэл учруулах, байгал орчны журмын эсрэг зэрэг 5 төрлийн гэмт хэргийн үйлдэгдэж байгаа шалтгаан нөхцлийг тогтоох зорилгоор ажлын хэсгүүд байгуулан судалгаа хийж, цаашид хийж гүйцэтгэх ажлыг тодорхойлон, судалгааны дүнг танилцуулан, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд ашиглаж байна.

Гэмт хэрэг гарсан шалтгаан нөхцөл нь ихэнхдээ ажилгүйдэл, архидаан согтуурснаас, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгджээ.

Прокурорын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх заалт, мөн хуулийн 36.4-т заасны дагуу аймгийн Прокурорын газар нь гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгуулах зорилгоор 2015 онд 32, 2016 онд 48, 2017 оны эхний хагас жилд 40 прокурорын мэдэгдэл бичиж, нийт 102 хариуг хүлээн авсан байна. Мөн сумдын ГХУС салбар зөвлөл болон аж ахуйн нэгж байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилтай танилцан, мэргэжлийн туслалцаа үзүүлж, илэрсэн зөрчлийг арилгуулан, аймгийн ГХУСА33-д санал оруулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэжээ.

1.2 Гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг арилгах нийгэм, эдийн засаг, эрх зүйн арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлж ажилласан байна.

Аймгийн ГХУСА33 нь гэмт хэргийн шалтгаан нөхцлийг арилгах, урьдчилан сэргийлэх чиглэлээр жил бүр төлөвлөгөө гарган биелэлтийг тооцон ажиллаж байна.

Аймгийн ГХУСА33 нь 2015 онд “Аймгийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрсэн түвшинг ахиулж, тодорхой бодит ажилд анхаарал хандуулна” зорилтын хүрээнд 7 бүлэг, 47 ажил арга хэмжээ төлөвлөж бүрэн хэрэгжүүлэн ажилласан ба зөвлөлийн хурлыг сар болгон хийж, тухайн сард гарсан гарсан гэмт хэргийн талаар аймгийн Цагдаагийн газрын мэдээллийг сонсон, цаашид хийх ажлын чиглэл гарган ажилласан нь үр дүнтэй ажил болжээ.

2015 онд зөвлөлийн хурлыг 10 удаа хийж, 30 асуудал хэлэлцэж, 15 зөвлөмж, ажлын удирдамж чиглэл өгч, аймгийн ГХУСА33-ийн хуралдаанаас Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн холбогдох заалтыг байгууллага дээрээ хэрэгжүүлэх талаар зөвлөмж гаргаж, нийт 42 байгууллагад хүргүүлж хэрэгжүүлэх ажил зохион байгуулсан байна.

Аймгийн ГХУСА33-өөс аймгийн хэмжээнд орц, траншейгаар хоноглож байгаа орон гэргүй хүмүүсийн судалгааг нэг бүрчлэн гаргах чиглэлийг аймгийн Цагдаагийн газарт өгсний үндсэн дээр 52 хүний судалгааг гаргаж, зохицуулах зөвлөлд танилцуулан, хотын дотор байгаа 180-аад таггүй болсон траншейг тагтай болгон, хүн орогнох боломж нөхцлийг хааж, болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх, гэр оронтой болсон тохиолдолд тэнэмэл амьдралаа зогсоох боломжтой хүмүүсийг гэр оронтой болгох зэрэг ажлуудыг зохион байгуулжээ.

Мөн орон гэргүй архины хамааралтай, тэнэмэл иргэдэд нийгэм сэтгэл зүй, халамж үйлчилгээний тусламж үзүүлэх “Шинэ амьдрал төв”-ийн байр ашиглалтанд орсноор амьдрах таатай орчин, хөдөлмөр эрхлэх боломжоор бүрэн хангажээ.

Орхон аймгийн ГХУСА33-ийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 114, 12 дугаар сарын 21-ний өдрийн 143 дугаар тогтоолоор тус тус шинэчлэн баталжээ.

Орхон аймгийн Цагдаагийн газраас согтууруулах ундааны хэрэглээг бууруулах, түүнтэй холбоотой хүн амын эрүүл мэнд, нийгэмд учрах сөрөг үр дагаврыг багасгах зорилгоор бүтэн жилийн хугацаанд хэрэгжүүлэх “Орхон аймаг дахь архины аюултай хэрэглээг бууруулах нь” төсөлд шаардагдах 4 510 000 төгрөгийн санхүүжилтийг аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас гаргасан байна.

Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгаас аймгийн хэмжээнд ажиллаж байгаа “Олон нийтийн цагдаагийн ажилтнуудад” Хууль, эрх зүй, хүний эрхийн мэдлэг олгох, Харилцааны соёл, Биеийн хүч хэрэглэх, Холбооны хэрэгсэл ашиглах, Хамгаалах тусгай хэрэгсэл ашиглах, Хөдөлмөрийн аюулгүй байдлын тусгай хувцас өмсөж хэрэглэх, Галын бэлтгэлийн хичээл зэрэг сэдвээр танхимын 12, дадлагын 6 удаагийн сургалт явуулсан байна.

2017 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн хэмжээнд хэрэгжиж буй бодлого, төлөвлөлтийн хүрээнд аймгийн ИТХ-аас баталсан “Аймгийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хэв журам, сахилга хариуцлагыг дээшлүүлэх талаар 2013-2017 онд баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний 4 бүлэг 38 заалт бүхий төлөвлөгөөг хэрэгжүүлж, хэрэгжилтийг жил бүр аймгийн ИТХуралд хэлэлцүүлж, холбогдох арга хэмжээг авч ажиллажээ.

Аймгийн Засаг даргын 2017 оны А/146 дугаар захирамжаар батлагдсан удирдамжийн дагуу Орхон аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа эмийн сангуудад шалгалт хийж бүртгэл судалгааг шинэчлэн гаргасан байна. Орхон аймагт эм ханган нийлүүлэх байгууллага 8, эмийн сан 57, мал эмнэлэг 5 нийт 70 аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулж байгаагаас мансууруулах эм худалдаалдаг 1, сэтгэцэд нөлөөт эм худалдаалдаг 13 эмийн сан байна. Тус эмийн сангуудаар үйлчлүүлсэн өвчний учир мансууруулах эм хэрэглэдэг 81, сэтгэцэд нөлөөт эм бэлдмэл хэрэглэдэг 174 иргэдийн судалгааг гарган, эмийн сангуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллажээ.

Мансууруулах төрлийн ургамлыг устгах зорилгоор “Устгал 2017” хэсэгчилсэн арга хэмжээг 2 үе шаттайгаар зохион явуулахаар төлөвлөж, хэрэгжүүлж эхлээд байна. Энэ ажлын хүрээнд нийт 3 га газар ургасан зэрлэг олсны ургамлыг устгах ажлыг зохион байгуулжээ.

Хүн худалдах, садар самууныг сурталчлах, биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргүүдээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Ерөнхий боловсролын 10 сургууль, Их Дээд сургууль, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн 1 дүгээр курсын оюутнууд, нийт 125 сурагчдын дунд сургалт, сурталчилгааг зохион явуулсан байна.

Цагдаагийн газар, Тагнуулын газар, Гадаадын иргэн харьяатын газар хамтран хүн худалдаалах гэмт хэргийн талаар мэдээ, мэдээлэл солилцон ажиллах, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд холбогдох байгууллагын ажилтнуудын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор хамтарсан уулзалт зохион байгуулж цаашид хамтран ажиллах гэрээ байгуулан, гэрээнд заагдсан ажлуудыг тодорхой үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна.

Мөн олон нийтийн цагдаагийн цалингийн асуудлыг орон нутгийн төсвөөс шийдвэрлүүлж, нийт 25 олон нийтийн цагдааг гурвалсан гэрээгээр ажиллуулж, Цагдаагийн газраас удирдлагаар ханган ажиллаж байгаа нь үр дүнгээ өгсөн ажил болжээ.

Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааны түншлэлийг засаг захиргааны анхан шатны нэгжид бий болгох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг багийн түвшинд эрчимжүүлэх зорилгоор ИТХ, Цагдаагийн газар, багийн засаг даргын гурвалсан гэрээг байгуулан хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн хэмжээнд хэрэгжиж буй бодлого, төлөвлөлтийн хүрээнд аймгийн ИТХ-аас баталсан “Аймгийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хэв журам, сахилга хариуцлагыг дээшлүүлэх талаар 2013-2017 онд баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн зэрэгцээ аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулах ажлыг тусган, үүнтэй уялдуулан Цагдаагийн газрын даргатай үр дүнгийн гэрээг байгуулж, хэрэгжилтийг хагас бүтэн жилээр тооцон ажиллаж байна.

Тухайлбал: Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хууль хяналтын байгууллагуудын хүний нөөц, техник тоног төхөөрөмж, дэд бүтцийг шинэчлэн, хуульд заасан үүргээ стандартын дагуу хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх, аймгийн төвийн гудамж талбайг камержуулж, ашиглалт хамгаалалтыг сайжруулах, авто замын уулзваруудыг шат дараатайгаар өргөтгөх, гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, цагдаагийн байгууллагад дотоод холбоо, мэдээллийн нэгдсэн систем, бэлэн бус торгуулийн төхөөрөмж, бусад шаардлагатай дэмжлэгийг үзүүлэх, шинэ төрлийн гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, энэ чиглэлээр хуулийн байгууллагуудын ажилтнуудын мэргэжил ур чадварыг

дээшлүүлэх зорилтыг тусган жил бүрийн аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд хэрэгжүүлэх ажил, төсвийг тусган батлуулж, хэрэгжүүлж ажиллажээ.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хотын камерын засвар үйлчилгээг сайжруулах зорилгоор ажиллахгүй байгаа 89 камерыг сэргээн засварлах ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулан, ажлыг эхлүүлсэн байна.

Мөн аймгийн хэмжээнд “Шуурхай удирдлагын нэгдсэн төв”-ийг байгуулах, гудамж талбайн камержуулалтыг өргөтгөх ажлын төслийг боловсруулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2017 оны А/139 дүгээр захирамжаар байгуулан нийслэлийн шуурхай удирдлагын төв болон камержуулалтын ажилтай биечлэн танилцсан бөгөөд төслийг боловсруулах ажил хийгдэж байна.

1.3 Давтан гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх зорилгоор хорих ял эдлээд суллагдсан хүнд хуульд заасан журмын дагуу захиргааны хяналтыг тогтоон ажиллаж байна.

Эрүүгийн хуулийн 6.12, 6.13 дугаар зүйлд хугацаанаас өмнө суллагдсан, чөлөөлөгдсөн, мөн таван жилээс дээш хугацаагаар хорих ял эдлээд суллагдсан бол дахин гэмт хэрэг үйлдэх, нийгмийн хэв журам зөрчихөөс урьдчилан сэргийлэх зорилгоор захиргааны хяналт тогтоохоор заажээ.

Орхон аймгийн хэмжээнд 2015 онд 242 ялтан, 2016 онд 113 ялтан, 2017 оны эхний хагас жилийн байдлаар 115 ялтан захиргааны хяналтад байгаа бөгөөд хариуцсан хэсгийн байцаагч нар хяналт тавин ажиллажээ.

	2015	2016	2017.06.30.
<i>Шүүхээс тэнсэн суллагдсан</i>	149	81	49
<i>Хорих ангиас тэнсэн суллагдсан</i>	85	19	65
<i>Насанд хүрээгүй этгээдэд ялыг хойшлуулсан</i>	8	13	1
Нийт	242	113	115

ОНХ ажил хариуцсан ахлах байцаагч захиргааны хяналтад байгаа хүмүүсийн хувийн хэрэгтэй танилцан, хэсгийн байцаагч нарт зааварчилгаа өгөн ажилладаг байна. Хэсгийн байцаагч нар зааварчилгааны дагуу ажил зохиож, гарсан зөрчил дутагдлыг арилгасан тухайгаа илтгэх хуудсаар танилцуулж, шалгуулан ажиллаж байна.

2015 онд “Монгол Дизайнер” ТББ-тай хамтран “Хамтдаа” төслийг хэрэгжүүлэн сийлбэрчин, гуталчин, оёдол, мужаан, бариа засал, гоо сайханч, эсгий ноосон урлалч, арьсан урлалч зэрэг сургалтыг 3 үе шаттайгаар 150 хүнийг хамруулсан бол 2016 онд “Хандлага”, “Харилцаа”, “Өөрчлөлтийг өөрөөсөө эхлээ” төслүүд, ярилцлага зохион байгуулж давхардсан тоогоор 150 хүнийг хамруулан ажиллажээ.

Цагдаагийн газраас захиргааны хяналттай хүмүүсээс орон гэргүй болон мэргэжилгүй, ажилгүй иргэдэд аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт гэр олгуулах, мэргэжлийн чиг баримжаа олгох талаар материалыг хүргүүлэн, 10 иргэнд гэр олгуулахаар шийдвэрлүүлэн, ажилгүй байсан 12 хүнийг ажилд оруулан, 12 иргэнд мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтанд бүртгүүлсэн байна.

2015 онд Монгол улсын Хүний эрхийн үндэсний комиссын салбарын ажилтан Орхон аймагт ажиллаж, захиргааны хяналттай хүмүүст Хүний эрхийн талаар сургалт явуулан, тэдний санал хүсэлтийг сонсож, зөвлөгөө өгч ажилласан байна.

Захиргааны хяналт тавих журмын дагуу сар бүрийн 15-ны өдөр захиргааны хяналттай хүмүүсийг хэсгийн байцаагч уулзан, хувийн хэрэгт тэмдэглэгээ хийж ажиллахын зэрэгцээ захиргааны хяналтанд байгаа 189 хүнийг Шүүхийн шинжилгээний албатай хамтран генетикийн шинжилгээ ДНХ-н шинжилгээнд дээж авхуулан, шинжээч эмчээр хувийн хэрэгт тэмдэглэгээ хийлгэн, аймгийн прокурорын газрын хорих ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хяналтын прокурорт хувийн хэргийг хянуулан зааварчилгаа авч ажилласан байна.

Орхон аймгийн Цагдаагийн газарт хорих газраас суллагдсан хүүхэд байхгүй, хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн, ял хойшлогдсон 12 хүүхэд хяналтанд байгаа бөгөөд Цагдаагийн газрын хүүхдийн байцаагч захиргааны хяналтанд байгаа хүүхдүүдтэй сар бүр тогтмол уулзан хяналт тавьж, зөвлөгөө өгөн, сургалтанд хамруулан, хувийн хэрэгт тэмдэглэгээ хийлгэн ажилласан байна.

Мөн аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтэнтэй хамтран захиргааны хяналтанд байгаа хүүхдүүдийн ар гэрээр орон, эцэг эх, асран хамгаалагчтай уулзан зөвлөгөө өгч, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дахин гэмт хэрэг, зөрчилд холбогдуулахгүй байх талаар баталгаа гаргуулан авч, 2 хүүхдийг Төрийн бус байгууллагад уламжлан хичээлийн хэрэгсэл өгсөн байна.

Захиргааны хяналттай хүмүүсийг Цагдаагийн газарт 10 удаа цуглуулан уулзаж, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль болон бусад хууль тогтоомжоор зөвлөгөө өгчээ.

Цагдаагийн газрын хүүхдийн албанаас дээрх ял хойшлогдсон хүүхдүүдийн сургуулийн нийгмийн ажилтан, сургуулийн захирал нартай уулзан ярилцаж, хамтран хяналт тавин ажиллаж, асран хамгаалагч, халамжлан хүмүүжүүлэгч томилуулж, сар бүр асран хамгаалагч нартай уулзалт зохион байгуулан ажиллажээ.

Захиргааны хяналтанд байгаа дээрхи иргэдэд Цагдаагийн газрын сэтгэл зүйчээр “Хандлага”, “Харилцаа” сэдвээр 2 цагийн, “Аминчхан яриа” Төрийн бус байгууллагатай хамтран “Өөрчлөлтийг өөрөөсөө эхэлье” сэдэвт 5 хоногийн сургалтуудыг зохион явуулж, давхардсан тоогоор 120 хүнийг хамруулжээ.

2017 оны эхний хагас жилд шинээр батлагдсан Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн тэгшитгэлд хамрагдан, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газруудын харъяа хорих ангиудаас суллагдан ирсэн Орхон аймгийн харъяат 65 иргэнийг хүлээн авч Шүүхийн шинжилгээний албатай хамтран гарын болон хүнээс гаралтай биологийн дээж авах ажиллагааг зохион байгуулан, бүртгэлд оруулан Цагдаагийн газрын бүртгэл мэдээллийн санд оруулан, аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, багийн Засаг дарга нартай хамтран дээрх иргэдэд сургалт зохион байгуулан, ар гэрт нь хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулаж, оршин суух тодорхой хаяггүй 1 иргэнийг бүртгэлд хамруулан Эрүүгийн цагдаагийн тасгийн албан хаагч нартай уулзалт зохион байгуулжээ.

Захиргааны хяналтанд байгаа 115 материалыг аймгийн Прокурорын газарт хүргүүлэн хянуулж шинээр мөрдөгдөж байгаа Эрүүгийн хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд аймгийн Сум дундын шүүхээр шийдвэр гаргуулахаар хүргүүлсэн бөгөөд хугацаа дууссан 15 материалыг зогсоон, хилийн хориг цуцлуулах санал хүргүүлэн, шинээр хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн 3, хорих газраас хугацааны өмнө тэнсэн суллагдсан 1 хүний материалыг хүлээн авч хувийн хэрэг нээн аймгийн Прокурорын газарт хүргүүлжээ.

1.4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэн болон аж ахуйн нэгжийг татан оролцуулсан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах ажилд иргэд, байгууллагын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/657 дугаар захирамжаар “Байгууллага, аж ахуй нэгжүүдээс нийтийн эргүүлийн үүрэг гүйцэтгэх журам”-ыг баталж гаргасан байна. Журмын дагуу аймгийн Цагдаагийн газраас эргүүл хийх хуваарийг гарган, багийн засаг дарга, эргүүлд ажиллах аж ахуй нэгж байгууллагуудын дарга, захирал удирдах албан тушаалтанд хүргүүлэн эргүүлд гарах албан хаагч, ажилтан нарыг урьдчилан томилуулан ажиллаж байна. Оны эхний хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 280 аж ахуйн нэгж, байгууллагын давхардсан тоогоор 1052 ажилтан цагдаагийн алба хаагч нартай хамтран эргүүлийн үүрэг гүйцэтгэсэн байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, төрийн зарим чиг үүргийг ТББ-аар гүйцэтгүүлэх, хамтран ажиллах зорилгоор хорихоос суллагдсан болон хорихоос өөр төрлийн ял эдэлж буй захиргааны

хяналтад байгаа иргэд, гэмт хэрэгт холбогдсон хүүхдүүдэд сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх, архинд донтох өвчтэй иргэдэд сэтгэлзүйн эмчилгээ, зөвлөгөө, нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулах, шинэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа явуулах чиглэлээр 8 ТББ-тай гэрээ байгуулж ажиллахаар гэрээний төслийг бэлтгэсэн байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 10 дугаар тогтоолоор Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх болон түр саатуулах хашаа /байр/ ажиллуулах үйлчилгээний төлбөрийн хэмжээг, мөн ИТХТ-ийн 77-р тогтоолоор тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх гудамж, зам хамрах хүрээ, түр саатуулах хашаа, зогсоолын нийт талбайн хэмжээ, чирэгч, ачигч автомашины тоог тогтоож баталсан. Дээрх тогтоолоор аймгийн хэмжээнд тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх болон түр саатуулах хашаа /байр/-ны тоо 2 байхаар тогтоосны дагуу “Түнт хүрээ” ХХК-тай байгуулсан гэрээг цуцлан, “Түнт хүрээ” ХХК болон “Мега авто гоёл” ХХК-тай гэрээг шинэчлэн байгуулж, үйл ажиллагаанд хяналт тавин ажилласан байна.

Цахим гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлэх ажлыг төлөвлөн мөнгө угаах, авилга албан тушаал, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр ЦГ, Татварын хэлтэс, Мэргэжлийн хяналтын газар, Гаалийн байгууллага хамтран мэдээлэл солилцон ажиллаж байна.

Цагдаагийн газраас малын хулгайн гэмт хэрэг үйлдэгдсэн талаар иргэдээс гомдол мэдээлэл хүлээн авсан тохиолдолд тухайн алдагсан малыг эрэн сурвалжлах Асар санд зарлан “Малчдын лавлах-109” тусгай дугаар болон “Молор” телевиз, ФМ радио 88.8, www.todsuraq.mn вебсайт, todsuraq-19001922 тусгай дугаарын утас зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр Цагдаагийн газрын нийт алба хаагчид болон аймгийн малчид, мал бүхий иргэдэд мэдээ, мэдээлэл хүргэн танилцуулснаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаандаа ашиглаж байна.

1.5. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг иргэдэд мэдээлэх, сурталчлах, сургалт олон удаа зохион байгуулагдаж байгаа ч сургалтын үр дүнг тооцоогүй байна.

Аймгийн ГХУСАЗЗ-өөс хууль тогтоомж сурталчлах, соён гэгээрүүлэх ажлыг тасралтгүй, системтэй зохион байгуулсан байна.

2015-2016 онд Аймгийн ГХУСАЗЗ нь ТВ-10 телевизтэй гэрээ байгуулж 7 хоног бүрийн Пүрэв гарагийн 19.30 цагт “Хуулийн цаг” шууд нэвтрүүлгийг давталттайгаар тасралтгүй жилийн турш нэвтрүүлж, энэхүү нэвтрүүлэгт Шүүх, Прокурор, Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс, Эрүүл мэндийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Тахарын алба, Шүүхийн шинжилгээний алба зэрэг хууль хяналт, төр захиргааны байгууллагууд, аймаг, сумын Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх агентлагуудын холбогдох албан тушаалтнууд оролцож, хууль сурталчлах ажлыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулан ажиллажээ. Нийт 35 удаагийн нэвтрүүлгийг зохион явуулж давталттайгаар гаргажээ.

Мөн Тагнуулын ерөнхий газрын Орхон аймаг дахь газартай хамтран 2016 оны сонгуулийн үр дүнгээр бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт орсонтой холбогдуулан Төрийн байгууллагуудын удирдах ажилтан, нууцын ажилтнуудад Төрийн нууцын хадгалалт хамгаалалт сэдвээр сургалтыг амжилттай зохион байгуулжээ.

2017 оны эхний хагас жилд аймгийн хэмжээнд гэр бүл, орчиндоо байнга түгшүүр төрүүлдэг, архины хамааралтай болсон 289 иргэний судалгааг гарган, багуудын хэсгийн байцаагч нартай хамтран байнгын хяналт тавин ажиллаж байна.

Архины хамааралтай иргэд, эрүүлжүүлэгдэх, баривчлагдах арга хэмжээ авагдсан иргэдэд “Архидалт мансуурлын эсрэг ассоциац”, “Ариун хэлхээ” ТББ, “Аминчхан яриа” ТББ, Цагдаагийн газрын Гэр бүл хүчирхийлэл хариуцсан ахлах байцаагч, сэтгэл зүйч нар хамтран

16 удаагийн сургалтыг зохион байгуулж, архины хор хөнөөл, сайн дурын эмчилгээний талаар ойлголт өгч, сургалт сэтгэл заслын үйлчилгээг 3 удаа явуулсан байна.

Мөн хүүхдийг зам тээврийн осол зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, энэ ажилд эцэг эхчүүдийн оролцоог хангах зорилгоор “Сургуулийн цагдаа” эргүүлийн ажиллах журмын төслийг боловсруулан, аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурал болон ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж батлуулахаар бэлтгэсэн байна.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон хувийн хэвшлийн томоохон аж ахуйн нэгж, байгууллага, сургууль, баар ресторан, дэлгүүрүүдэд нийтээр амрах баяр ёслолын өдрүүдэд гэмт хэрэг, зөрчилгүй тэмдэглэж өнгөрүүлэх, байгууллага дээр хариуцлагатай эргүүл, жижүүр ажиллуулах, архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх талаар тухай бүр аймгийн Засаг даргын захирамжаар үүрэг чиглэл өгч, мэдээг авч ажиллаж хэвшжээ.

Аймгийн Цагдаагийн газар аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд “Хүний наймаа”-ны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлгийн материал 1680 ширхэгийг хийлгэх хөрөнгийг шийдвэрлэн, аймгийн хүн ам ихээр цуглардаг газруудад байршуулсан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар иргэд олон нийтэд хүртээмжтэй мэдээлэх зорилгоор www.police.or.gov.mn цахим хуудас болон facebook хаяг нээн ажиллуулж, иргэдэд өмнөх оны гэмт хэргийн нөхцөл байдалд дүгнэлт хийж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх, тодорхой төрлийн гэмт хэргийн гаралтыг бууруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журам сахиулах ажилд төрийн болон ТББ, аж ахуйн нэгж байгууллагуудыг оновчтой хэлбэрээр татан оролцуулах, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, үйл ажиллагааг нь дэмжих ажлыг зохион байгуулж, хамтран ажиллаж байгаагийн үр дүнд 2017 оны эхний 6 сарын байдлаар дээрэмдэх, Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх, Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох зэрэг гэмт хэрэг өсөөгүй хэвээр, гэмт хэргийн илрүүлэлт 1.4 пунктээр өссөн үзүүлэлтэй байна.

Орхон аймаг дахь
Төрийн аудитын
газарГэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр үр дүнтэй
байна уу.**Бүлэг 2****Бүх төрлийн гэмт хэргийн тоон үзүүлэлт буурч байгаагаас
харахад жил бүрийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд үр дүнтэй
хэрэгжсэн байна.****2.1 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр өнөөгийн хэрэгцээ
шаардлагатай нийцсэн байна.**

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д *“Нутгийн захиргааны байгууллага харъяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд гэмт хэрэг, нийгмийн хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулахдаа иргэдийг дараах хэлбэрээр татан оролцуулна: Иргэдийг нийтийн эргүүлд гаргах, хэв журмын урамшилтай эргүүл, жижүүрээр томилох”* гэж заасан байна.

Монгол улсын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд засаг захиргааны анхан шатны нэгж багуудын үүрэг хариуцлагыг дээшлүүлж, хариуцсан нутаг дэвсгэртээ хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулахад иргэд, байгууллагын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор аймгийн ГХУСАЗЗ, аймгийн Цагдаагийн газар, Баян-Өндөр сумын 21 баг, Жаргалант сумын 3 багуудын Засаг дарга нартай гурвалсан гэрээг дөрөв дэх жилдээ байгуулан ажилласан байна.

2016 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн аймгийн ГХУСАЗЗ-ийн хурлаар Гурвалсан гэрээг дүгнэсэн ажлын хэсгийн илтгэл, мэдээллийг сонсож эхний гурван байрт шалгарсан Баян-Өндөр сумын Наран, Баянцагаан, Цагаанчулуут багуудыг өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан байна.

Иргэдийн тав тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд СӨХ-дын оролцоог нэмэгдүүлж, энэ талаар зохиож буй ажлыг идэвхжүүлэх зорилгоор Баян-Өндөр суманд үйл ажиллагаа явуулдаг нийт Сууц өмчлөгчдийн холбоодтой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гурвалсан гэрээ байгуулан ажилласан бөгөөд гэрээний биелэлтийг дүгнэж эхний гурван байрт шалгарсан Алтандуулга, Уурхайчин, Бадмаараг СӨХ-дыг шагнаж урамшуулсан байна.

Аймгийн хэмжээнд насанд хүрээгүй хүүхдүүдээс гэмт хэрэг үйлдэх, зөрчил гаргах, өөрсдөө гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болох явдал жилээс жилд нэмэгдэх хандлагатай байгаад тус зөвлөлөөс дүгнэлт хийж, Боловсрол соёлын газар, Ерөнхий боловсролын болон Их дээд сургууль, МСҮТ-ийг энэ чиглэлд төвлөрүүлэх, энэ асуудалд чиглэсэн хандлагыг бий болгох зорилгоор 2012-2013 оны хичлээлийн жилээс эхлэн гурвалсан гэрээ байгуулан ажиллаж байгаа нь үр дүнгээ өгсөн ажил болсон байна. Гурвалсан гэрээ байгуулан ажилласны үр дүнд насанд хүрээгүй хүүхдийн гэмт хэргийн тоо жилээс жилд буурч, хамран сургах тойргийн хүүхдүүдээс сургууль завсардах явдал багассан, 2015-2016 оны хичээлийн жилд байгуулсан гэрээг дүгнэж эхний гурван байрт шалгарсан Баян-Өндөр цогцолбор сургууль, Жаргалант сумын дунд сургууль, 17-р сургуулийг шагнаж урамшуулжээ.

Хүчирхийлэлд өртсөн иргэдийг түр хамгаалах байрны үйл ажиллагааг дэмжих, иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлыг орон нутгийн төсвөөс /энэ онд 25,0 сая төгрөг/ санхүүжүүлж, үйл ажиллагаанд нь хяналт тавин хамтран ажиллаж байна.

Цагдаагийн байгууллага нь хүчирхийлэлд өртсөн хохирогчийг хамгаалах байрны асуудлын талаар Хүүхэд гэр бүл, хөгжлийн хэлтэстэй хамтран аймгийн Засаг даргын Тамгын газарт санал хүргүүлсний дагуу энэ асуудлаар Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдаж “Хохирогчийг хамгаалах төв” нэртэйгээр “Оюу” сэтгэц, наркологийн эмнэлгийн байрыг

түшиглэн 24 цагийн үйл ажиллагаатайгаар ашиглалтанд орж, уг байр нь 70356001 дугаарын утас ажилуулан, үйл ажиллагааг “Ариун хэлхээ” төрийн бус байгууллага хариуцан Цагдаагийн газартай хамтран ажилласан байна.

Хамгаалах байранд 2016 оны 12 сарын байдлаар нийт 163 иргэн хандаж зөвлөгөө, тусламж авч, 72 хүүхэд 32 том хүн, нийт 104 хүн 439 хоног байрлажээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь, Цагдаагийн байгууллагаас 2016, 2017 оны эхний хагас жилийн байдлаар, насанд хүрээгүй хүмүүсээс үйлдэгдсэн гэмт хэргийн талаарх авсан судалгаан дээр үндэслэн насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэхийн тулд Монгол улсын Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд заасан насанд хүрээгүй хүмүүст холбогдох зүйл заалтын дагуу “САНАМЖ”-ийг хэвлэн бэлтгэж, Цагдаагийн байгууллагатай хамтран аймгийн хэмжээнд архи согтууруулах ундаа худалдаалдаг, түүгээр үйлчилдэг 449-н аж ахуй нэгжүүдэд хүргүүлсэн байна.

Эцэг эхийн анхаарал халамж дутмаг гэсэн мэдээлэл ирсэн хүүхэд тэдний гэр бүлтэй 18 өрхийн 24 хүнтэй уулзаж, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хүрээнд зөвлөгөө өгч ажиллажээ. Хогийн цэг дээр ажилладаг гэр нь байдаг нийт 25 хүүхэд, эцэг эхэд хогийн цэг дээр ажиллах нь эрүүл мэндэд сөрөг нөлөөтэйг таниулах сургалт өгч, хүүхдүүдийн дунд гүйлтийн тэмцээн зохион байгуулжээ.

Гэр бүлийн чиглэлээр Гэр бүлийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хүрээнд 28 өрхөд нийгэм, сэтгэл зүйн зөвлөгөө өгч ажилласан байна. “Эцгийн хайр” зөвлөгөөнийг зохион байгуулж зөвлөгөөнд 21 багийн 100 гаруй аавууд оролцсон байна.

Цагдаагийн газар гадаадаас ажиллах хүч оруулж ирж байгаа аж ахуйн нэгжүүдэд гадаадын иргэн харъяатын албатай хамтарсан шалгалтыг 3 удаа зохион байгуулан ажиллаж, гадаадын иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгөх ажлыг хийжээ.

Цагдаагийн газар “Хүн худалдаалах” болон бусад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор Номин телевизтэй хамтран 2 минутын богино хэмжээний шторк хийлгэн нэвтрүүлсэн ба 7 хоног бүрийн баасан гарагт “Дуудлага” нэвтрүүлэг бэлтгэн тухайн сард өсөлттэй байгаа гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллаж байна.

Насанд хүрээгүй охидыг садар самуунд уруу татах, хүчээр биеийг нь үнэлүүлэх гэмт хэргийн талаар мэдээ, мэдээлэл олох, энэ төрлийн гэмт хэргийг үйлдэж болзошгүй этгээдүүдийг гүйцэтгэх ажлын хяналтанд авах талаар баг хариуцсан эрүүгийн төлөөлөгч нарт үүрэг чиглэл, өгч ажилласан байна. Мөн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлж байгаа гадаад оронд тэтгэлэгт сургалтанд суралцуулна, ажилд зуучилна гэсэн заруудад хяналт тавин ажиллаж, иргэдэд холбогдох мэдээллийг өгч ажилласан байна.

Аймгийн хэмжээнд “Шинэ жил”, “Сар шинэ-2016”, “Согтуу”, “Хууль бус тээвэрлэлт, жолоочийн хариуцлагын даатгал, хууль журмын хэрэгжилт”, “Зогсолт зогсоол”, “Явган гарц”, “Мотоцикл”, “Аюулгүй тээвэр-техникийн хяналт”, “Осолгүй жолооч-Жаргалтай гэр бүл”, “Оюутан тээвэр-1”, “Хөдөлгөөнт эргүүл”, “Оюутан тээвэр-2”, “Хамгаалах бүс-Хамгаалалтын суудал”, “Авто тээврийн хэрэгслийн стандарт”, “Ургац-2016”, “Тусгай дуут гэрэл дохио хэрэглэх журам”, “Явган гарц”, “Жолоодох эрх” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг төлөвлөгөө, удирдамжийн дагуу зохион явуулан, үр дүнг тооцож, зөрчил гаргагчдад хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож, үйл ажиллагааны явц үр дүнгийн талаар орон нутгийн телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол мэдээлэн ажиллажээ.

Мөн Орхон аймгийн Ерөнхий боловсролын сургуулиудын нийгмийн ажилтан, багийн зохион байгуулагч нарыг оролцуулан, хүн худалдах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн Хүүхдийн ордонд сургалт зохион байгуулж, Хүйсийн тэгш эрхийн төвөөс хүн худалдах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөгөөнийг ГБХЗХГ, аймгийн ГХУСАЗЗ, Дэлхийн зөн ОУБ, Баян-Өндөр сумын ЗДТГ, “Ариун хэлхээ” ТББ, Орших кино театр хамтран зохион байгуулсан байна. Аймгийн хэмжээнд өрх толгойлсон 133 эрэгтэй ганц бие, өрх тэргүүлэгч байгаа бөгөөд 1-18 насны 264 хүүхэд амьдарч байна.

Аймгийн Прокурорын газар нь 2015 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийх ажлын төлөвлөгөө гарган биелэлтийг тооцон ажилласан ба ажилтнууд ерөнхий боловсролын 17 сургууль, Баян-Өндөр сумын 3 баг, Жаргалант сум, “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн 10 цех зэрэг 28 аж ахуйн нэгж, байгууллага дээр очиж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 81 удаа яриа, танилцуулга хийн, 3388 хүн хамруулсан байна.

2.2 ГХУСА33 болон Цагдаа, Прокурорийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлууд давхардаж байна.

ГХУС тухай хуульд зааснаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг улсын хэмжээнд Хууль зүйн сайдаар, аймаг, нийслэл, сум, дүүрэгт түүний ИТХТ-ийн даргаар ахлуулсан орон тооны бус зохицуулах зөвлөл гүйцэтгэж байна.

Орхон аймгийн болон сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шат шатны ИТХ-аараа хэлэлцэн баталж, үйл ажиллагаагаа явуулж байна.

ГХУСА33 нь тухайн жилийн төлөвлөгөөг боловсруулахдаа зөвлөлийн гишүүдээс ирүүлсэн саналыг үндэслэн боловсруулж, зөвлөлийн хурлаар хэлэлцэж баталдаг байна.

Төлөвлөгөөг боловсруулахдаа салбар салбарын саналыг тусган боловсруулж байгаа нь сайшаалтай хэдий ч, аймаг болон сумдын ГХУСА33 нь тухайн жилийн төлөвлөгөөний биелэлтийг гаргадаггүй ба холбогдох байгууллагуудаас ирсэн ажлын тайланг нэгтгэн, хийсэн ажлаа тайлагнадаг байна.

2.3 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлүүдийн үйл ажиллагаа үр дүнтэй байна.

Орхон аймгийн ГХУСА33-ийн бүрэлдэхүүнийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 115 дугаар тогтоолоор шинэчлэн байгуулсан. Аймгийн ГХУСА33-ийн даргаар аймгийн ИТХ-ын дарга, орлогч даргаар аймгийн Засаг дарга, нарийн бичгийн даргаар аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, гишүүдэд аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Цагдаагийн газрын дарга, Орхон аймгийн ерөнхий прокурор, Орхон аймаг дахь шүүхийн Тамгын газрын дарга, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны дарга, Шүүхийн шинжилгээний албаны дарга, Онцгой байдлын газрын дарга, Орхон аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөлийн дарга, Орхон аймаг дахь Тагнуулын газрын дарга, Баян-Өндөр сумын ИТХ-ын дарга, Жаргалант сумын ИТХ-ын дарга, Гал голомт хөдөлгөөний Орхон аймаг дахь салбар хүрээний тэргүүн, Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн Хууль эрх зүйн газрын дарга гэсэн бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

2015 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр хуралдсан аймгийн ИТХ-ын ээлжит XXV хуралдаанаар аймгийн ИТХ-аас баталсан “аймгийн Засаг дарга, түүний тамгын газраас аймгийн хэмжээнд “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хэв журам, сахилга хариуцлагыг сайжруулах” 2013-2017 онд баримтлах бодлого, авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний биелэлтийг хэлэлцэж хангалттай хэрэгжиж байгаа гэж дүгнэсэн байна.

Аймгийн ГХУСА33-ийн бүрэлдэхүүнд багтдаг хууль, хяналтын болон төрийн байгууллагуудад Орхон аймгийн 21 багийг хуваарилан хариуцуулж, тус багуудаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж буй ажилд нь мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, тодорхой ажлыг хамтран зохион байгуулахыг чиглэл болгосон бөгөөд энэ талаарх ажлын тайланг аймгийн ГХУСА33-д хагас, бүтэн жилээр тайлагнаж хийсэн ажлаа дүгнүүлж байхаар шийдвэрлэсэн байна. Ингэснээр багуудад гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил зөв зохион байгуулалттайгаар явагдах, хууль хяналтын байгууллагуудтайгаа харилцан мэдээлэл сонсож хамтран ажиллах нөхцөл бүрдүүлсэн байна.

Аймгийн ГХУСА33-ийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссаны дагуу зөвлөлийн хуралдаанаар аймгийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж буй ажил, цаашид анхаарах асуудлын талаар аймгийн Засаг даргын илтгэл, мэдээллийг сонсож, анхаарах асуудал цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцэж, аймгийн Засаг даргад зөвлөмж, чиглэл хүргүүлж ажиллажээ.

Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, цаашид зохион байгуулах ажлын талаарх аймгийн Цагдаагийн газрын саналыг хэлэлцэж “Устгал” арга хэмжээний төлөвлөгөөг батлаж, шаардагдах зардал болох 3 сая төгрөгийг шийдвэрлэжээ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн Цагдаагийн газар, Баян-Өндөр, Жаргалант сумын багуудын Засаг дарга нартай байгуулах гурвалсан гэрээний төслийг заалт бүрээр хэлэлцэж, гэрээг байгуулах шийдвэрийг гаргаж Баян-Өндөр, Жаргалант сумын нийт 24 багийн Засаг дарга нартай 5 сая төгрөгийн шагналын сан бүхий гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын идэвх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор гэрээ байгуулан ажиллажээ.

Бүх төрлийн гэмт хэргийн тоон үзүүлэлт буурч байгаагаас харахад жил бүрийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд үр дүнтэй хэрэгжсэн байна. Хүснэгтээр харуулвал:



Тоон үзүүлэлтээс харахад 2015-2016 онуудад:

- Залилан мэхлэх гэмт хэрэг 51.8 хувиар,
- Хулгайн гэмт хэрэг 15.2 хувиар,
- Бусдын бие махбодод гэмтэл учруулах гэмт хэрэг 5.2 хувиар,
- Хүн амины хэрэг 30.0 хувиар,
- Бусдыг амиа хорлоход хүргэх 50.0 хувиар,
- Булаах гэмт хэрэг 50.0 хувиар,
- Дээрэм 36.8 хувиар,
- Залилан 48.1 хувиар,
- Завшиж үрэгдүүлэх 62.9 хувиар,
- Танхайрах гэмт хэрэг 7.7 хувиар,
- Бусад гэмт хэргүүд 7.3 хувиар тус тус буурчээ.

Сумдын салбар зөвлөл нь тухайн нутаг дэвсгэрийн онцлогт нийцсэн журмыг ИТХ-аар батлуулан мөрдөж, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журам хангахтай холбогдсон хууль тогтоомж, дээд шатны зөвлөлийн шийдвэрийг биелүүлж ажиллажээ.

Орхон аймаг дахь
Төрийн аудитын
газарГэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд
төсвийн хөрөнгө үр ашигтай зарцуулагдаж байна уу.**Бүлэг 3***Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсөв хуульд
зааснаас доогуур төлөвлөгдөн батлагдаж байгаа боловч батлагдсан
хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.***3.1 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсвийг хуульд
зааснаас 2015 онд 79.7 сая, 2016 онд 136.7 сая, 2017 онд 63.1 сая төгрөгөөр тус
тус дутуу төлөвлөсөн байна.**

Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулах төсөв
хөрөнгийг тухайн жилд ГХУС тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-т “Тухайн жил шүүхийн
шийдвэр биелүүлэх, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийг арилгах чиглэлээр
улсын орлого болгосон, торгох ял ногдуулж төсөвт тушаасан мөнгөний 40 хувьтай тэнцэх
хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан дараагийн жилийн
орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ” гэж заасны дагуу батлагдаагүй байна.

Торгууль, шийтгэврийн орлогоос батлагдсан хувь хэмжээг хүснэгтээр харуулбал
дараах байдалтай байна. Үүнд:

№	он	Торгууль, шийтгэврийн орлого	Торгууль, шийтгэврийн орлогоос тооцох дүн /40 хувь/	Батлагдсан төсөв		Зөрүү
				дүн	хувь	
1	2015	399.4	159.7	80.0	20.0	79.7
2	2016	538.2	215.2	78.5	14.5	136.7
3	2017	251.7	100.6	37.5	14.8	63.1
	Дүн	1189.3	475.5	196.0	16.4	279.5

/сая.төгрөгөөр/

Тайлант онуудад ГХУС үйл ажиллагааны санхүүжилтэд нийтдээ 475.5 сая төгрөг
баталж орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх ёстой байсан бол 196.0 сая төгрөг буюу 58.8
хувиар дутуу санхүүжүүлсэн байна.

2015-2016 оны орлогын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

№	Орлогын нэр	2015 он	2016 он	2017.06.30
1	МХГ хүү торгууль	47.6	39.8	23.9
2	Цагдаагийн газрын хүү торгууль	276.4	469.2	223.6
3	Бусад хүү торгууль	75.4	29.2	4.2
	Орлогын дүн	399.4	538.2	251.7
Үзүүлэлт	Хуульд заасан ГХУС зөвлөлд зарцуулах дүн /40%/	159.7	215.2	100.6
	ГХУС зөвлөлд олгосон санхүүжилт	80.0	78.5	37.5
	Зөрүү	79.7	136.7	63.1

/сая төгрөгөөр/

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19.1 дэхь заалтыг хэрэгжүүлэн ИТХ,
ГХУС үйл ажиллагаанд зарцуулах хөрөнгийг орон нутгийн төсвөөс бүрэн санхүүжүүлэхэд
анхаарч ажиллах нь зүйтэй байна.

3.2 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төсвийн хөрөнгийг ГХУС тухай хуулийн 19 дүгээр зүйлийн дагуу зарцуулж ирсэн байна.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл нь 2015-2016 онд 158,5 сая, 2017 онд 37.5 сая төгрөгийг АИТХ-ын төсөвт хөтөлбөр хэлбэрээр батлуулан, санхүүжилт авч зарцуулахдаа Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийг хэрэгжүүлж ажиллажээ. Үүнд:

/сая.төгрөгөөр/				
№	Он	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
1	2015	80.0	41.6	38.4
2	2016	78.5	78.5	0
3	2017.6.30	37.5	30.3	7.2
	Дүн	196.0	150.5	45.5

Аймгийн ГХУСАЗЗ 2015, 2016, 2017 оны эхний хагас жилд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг дараах чиглэлээр зарцуулсан байна. Үүнд:

/сая.төгрөгөөр/					
№	Үзүүлэлт	2015 онд	2016 онд	2017 оны эхний хагас жилд	Нийт
1	Хууль сахиулах байгууллага болон иргэд, байгууллагын дунд зохиож байгаа сургалт, сурталчилгаанд	38.7	41.2	30.3	110.2
2	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг шагнаж, урамшуулахад	1.6	32.8	0.0	34.4
3	Цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд шаардлагатай техник, хэрэгслийн зардлыг санхүүжүүлэхэд	0.1	3.4	0.0	3.5
4	Бусад	1.2	1.1	0	2.3
	Дүн	41.6	78.5	30.3	150.4

Дээрх хүснэгтээс харахад батлагдсан хөрөнгийг ГХУС тухай хуульд заасны дагуу зарцуулжээ. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулахад хөрөнгийн талаар хүндрэл учраагүй байна.

3.3 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулагдсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Аймгийн ГХУСАЗЗ өөрсдийн эрх хэмжээнийхээ дагуу тогтоол гаргаж байгаа нь хөрөнгө зарцуулах үндэслэл болж байна.

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хууль хяналтын байгууллагуудын хүний нөөц, техник тоног төхөөрөмж, дэд бүтцийг шинэчлэн хуульд заасан үүргээ стандартын дагуу хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх, аймгийн төвийн гудамж талбайг камержуулж, ашиглалт хамгаалалтыг сайжруулах, авто замын уулзваруудыг шат дараатайгаар өргөтгөх, гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, цагдаагийн байгууллагад дотоод холбоо, мэдээллийн

нэгдсэн систем, бэлэн бус торгуулийн төхөөрөмж бусад шаардлагатай дэмжлэгийг үзүүлэх, шинэ төрлийн гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, энэ чиглэлээр хуулийн байгууллагуудын ажилтнуудын мэргэжил ур чадварыг дээшлүүлэх зорилтыг тусган жил бүрийн аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд хэрэгжүүлэх ажил, төсвийг тусган батлуулж, хэрэгжүүлэн ажиллажээ.

Дээрх ажлын хүрээнд 2017 онд орон нутгийн төсвөөс:

- Камерын засвар үйлчилгээ 20 сая,
 - Олон нийтийн цагдаагийн урамшуулал 116 сая,
 - Цагдаагийн газрын шуурхай албаны автомашины сэлбэг хэрэгсэл, шатахууны зардал 35 сая,
 - Гэр хорооллын цагдаагийн байр болон эрүүлжүүлэх баривчлах байрны засвар 88,5 сая
 - Архины архаг хэрэглээтэй иргэдийн албадан эмчилгээ 134 сая,
 - Иргэдээс гэмт хэргийн талаар төлбөртэй мэдээлэл авах үйл ажиллагаанд 5 сая
- нийт 398.5 сая төгрөгийг** аймгийн ИТХ-аар батлуулан хэрэгжүүлж ажиллаж байна.

Аймгийн Цагдаагийн газар нь 2015-2017 оны эхний хагас жилд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан дараах хөрөнгийг зарцуулахаар төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулсан байна. Үүнд:

/сая.төгрөгөөр/					
№	Үзүүлэлт	2015 он	2016 он	2017 оны эхний хагас жил	Нийт
1	Хууль сахиулах байгууллага болон иргэд, байгууллагын дунд зохиож байгаа сургалт, сурталчилгаа	17.6	14.6	5.5	37.7
2	Эргүүл, жижүүр, олон нийтийн цагдаагийн ажилтныг урамшуулах	77.7	114.0	58.3	250.0
3	Цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд шаардлагатай техник, хэрэгслийн зардлыг санхүүжүүлэх	51.6	10.9	17.6	80.1
4	Шатахуун	20.0	22.1	12.0	54.1
5	Бусад зардал	8.9	22.6	12.8	44.3
	Дүн	175.8	184.2	106.2	466.2

Дээрх зардлуудыг эх үүсвэрээр задлан харуулвал:

/сая.төгрөгөөр/					
№	Эх үүсвэр	2015 онд	2016 онд	2017 оны эхний хагас жилд	Нийт
1	ЗДТГ	130.5	125.4	91.7	347.6
2	ИТХ	12.3	18.0	2.5	32.8
3	Эрдэнэт сан	33.0	40.8	12.0	74.8
	Дүн	175.8	184.2	106.2	466.2

Аймгийн Прокурорын газар нь 2015 онд улсын төсвөөс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд нийт 3.2 сая төгрөгийн санхүүжилт, 2016 онд 0.8 сая төгрөг, аймгийн орон нутгийн төсвөөс 3.9 сая төгрөг, нийт 10.7 сая төгрөгийн санхүүжилт авч дараах чиглэлээр зарцуулсан байна. Үүнд:

/сая.төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2015 онд	2016 онд	2017 оны эхний хагас жилд	Нийт
1	Сургалт, сурталчилгаа, мэдээлэл	3.0	4.1	2.8	9.9
2	Задлан шинжилгээнд оролцсон ажилчдын урамшуулал	0.2	0.6	0	0.8
	Дүн	3.2	4.7	2.8	10.7

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19.3-т заасан чиглэлд хамаарахгүй задлан шинжилгээнд орж ажилласан ажилчдын урамшуулалд 0.8 сая төгрөг зарцуулсан байна.

3.4 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зориулагдсан зардлаас хуульд зааснаас өөр зориулалтаар хөрөнгө зарцуулсан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19-р зүйлийн 19.5-д “Хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд тухайн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Төсвийн тухай хууль тогтоомжид заасан эрх бүхий этгээд хяналт тавина” гэсэн заалтын дагуу аймгийн ИТХ-аас хөрөнгийн зарцуулалтанд хяналт тавьж ажилласан байна

Баян-өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргын 2015 оны 10-р сарын 26-ний өдрийн 41 тоот захирамжаар 2015 оны 11 сарын 06-ний өдрөөс 09-ны өдрүүдэд Дорноговь аймгийн Сайншанд сумын ИТХ-ын дэргэдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн ажлын туршлага судлах 13 албан хаагч албан тоилолт зардалд 1170.0, 2016 оны 10-р сарын 05-ний өдрийн 37 тоот захирамжаар 2016 оны 11 сарын 20-ний өдрөөс 22-ны өдрүүдэд Дархан уул аймагт туршлага судлах албан томилолт зардалд 1065.0, нийт 2235.0 мянган төгрөгийг сумын ГХУСАЗЗ-ийн зардлаас гаргасан нь ГХУС тухай хуулийн 9.4 “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Орхон аймаг дахь
Төрийн аудитын
газарХууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан
сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүн

Дүгнэлт, зөвлөмж

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна.

- Гэмт хэргийн гарч байгаа шалтгаан, нөхцлийг тогтоох чиг үүргийн хэрэгжилтийг 2015-2016 онтой харьцуулахад хулгайн гэмт хэрэг 15.2 хувь, бусдын бие махбодод гэмтэл учруулах гэмт хэрэг 5.2 хувь, хүн амины хэрэг 30.0 хувь, бусдыг амиа хорлоход хүргэх гэмт хэрэг 50.0 хувь, булаах гэмт хэрэг 50.0 хувь, дээрэм 36.8 хувь, залилан 51.8 хувь, завшиж үрэгдүүлэх 62.9 хувь, танхайрах гэмт хэрэг 7.7 хувь, бусад гэмт хэргүүд 7.3 хувиар тус тус буурч, гэмт хэргийн илрүүлэлт 1.4 пунктээр өссөн үзүүлэлтэй байна.
- Бүх төрлийн гэмт хэргийн тоон үзүүлэлт буурч байгаагаас харахад жил бүрийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд үр дүнтэй хэрэгжсэн байна.
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсөв хуульд зааснаас доогуур төлөвлөгдөн батлагдаж байгаа боловч батлагдсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Дээрхээс үндэслэн хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж байгаа боловч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсвийг хуульд зааснаас доогуур төлөвлөн зарцуулсан байна гэсэн дүгнэлт өгч байна.

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг доорх албан тушаалтнуудад зөвлөж байна.

Аймгийн ГХУСАЗЗөвлөлийн нарийн бичгийн дарга Д.Эрдэнэцэцэг, аймгийн ИТХ-ын хурлын бодлого, хяналт хариуцсан ажилтан, нягтлан бодогч Б.Золоо нарт:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19.1 дэх заалтыг хэрэгжүүлэн ажиллаж, хуульд заасан хувь хэмжээгээр төсвийг батлуулан, тухай жилд холбогдох орлогын гүйцэтгэлээр төсвийн тодотголд төлөвлөн батлуулах,
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг иргэдэд мэдээлэх, сурталчлах зардлын үр дүнг тооцож байх,
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг сурталчлах сургалтуудын үр дүнг тухай бүр тооцон тайланд тусгаж байх,
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19.5. дахь заалтыг хэрэгжүүлэн сумын ГХУСАЗЗ-ийн зардлаас гаргасан хөрөнгөнд тавих хяналтыг сайжруулахыг тус тус зөвлөж байна.

Аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулж 2018 оны 05-р сарын 30-ны дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар ирүүлэх.

ТАНИЛЦСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРМАНДАХ

ТАЙЛАН БИЧСЭН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ЭРДЭНЭ

АУДИТОР

О.ДАШЖАМЦ

Б.ЭРГЭНЭГ
2017.10.25
МД



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

ОРХОН АЙМГИЙН
ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВТӨЛ

61000, Орхон аймаг, Амарын талбай, УБД 20/26

Утас: 70350493, Факс: 70352631

2017.10.25 № 38
тандай _____ -ны № _____ -т

Хариу хүргүүлэх тухай

Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлангийн төсөлтэй холбоотой санал байхгүй болно.

ДАРГА



Б.ПҮРЭВЛХАГВА

C:\My documents \toot\ A4

00100095

Зөргөжүүлж
2017.10.25
[signature]



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗАР

61000 Баян-Өндөр сум, Эрдэнэт, Баянцагаан баг
УБД-9043004, Утас: 70359324, Факс: 70352616

2017.10.25 № 46/02-4902

танай _____-ны № _____-т

Г ОРХОН АЙМАГ ДАХЬ АУДИТЫН Г
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ц.НАРМАНДАХ ТАНАА

Тус Цагдаагийн газраас "Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүн" гүйцэтгэлийн аудит хийсэн тайлантай танилцлаа.

Тайлангийн төсөлд тусгах саналгүй бөгөөд танай байгууллагаас гаргасан төсөлтэй санал нэг байна.

ДАРГА, ЦАГДААГИЙН
ХУРАНДАА



А.БАТБАЯР

D:/My documents/A-5.doc

012056



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2017 оны 10 сарын 24 өдөр

Дугаар 16/88-ОРА-2017/03-ГА

Эрдэнэт хот

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аймгийн Прокурорын газар Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хөрөнгөнөөс 850,000 төгрөгийг задлан шинжилгээнд оролцсон ажилчдын урамшууллыг олгоход зарцуулсан байна.

Энэ нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19.4-т "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно." гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх..." Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д "...дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө", 4.1.5-д "Байгуулсан гэрээ хэлцэл, мөрдөж байгаа хууль, тогтоомж, дүрэм, журмын шаардлага нөхцөл хангаагүй" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Аймгийн Прокурорын газар нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хөрөнгөнөөс 850,000 төгрөгийг задлан шинжилгээнд оролцсон ажилчдын урамшууллыг олгоход зарцуулсан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2018 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Орхон аймгийн Ерөнхий прокурор, хууль цаазын итгэмжит зөвлөх Г.Эрдэнэбаатарт даалгав.

2017 02 64

ӨГСӨН ¹	АЛБАН ШААРДЛАГЫГ ЗӨВШӨӨРСӨН
ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРМАНДАХ АУДИТОР О.ДАШЖАМЦ	ОРХОН АЙМГИЙН ЕРӨНХИЙ ПРОКУРОР, ХУУЛЬ ЦААЗЫН ИТГЭМЖИТ ЗӨВЛӨХ ГЭРДЭНЭБААТАР

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагддаггүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д
"Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд
зорчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан
тушаалтанд хүргүүлнэ" гэж зөвснө дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан
тушаалтанд санал хүргүүлнэ.